

Аудит хийгдэх нэгж:  
Төрийн захиргаа, удирдлагын газар

Огноо:  
2025.03.20

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

## **ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН**

**Аудитын нэр: Шилэн данс**

**Жил: 2024 оны жилийн эцэс**

**Улаанбаатар хот**

**2025 он**

## НЭГ. АУДИТЫН ЗОРИЛГО

Байгууллагын төсөв, төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр гаргах үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, иргэд олон нийтэд мэдээллийг нээлттэй, үнэн зөв, цаг хугацаанд нь мэдээлсэн шилэн дансны мэдээллийн санг бүрдүүлэхэд аудитын зорилго оршино.

## ХОЁР. ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ

Ашигт малтмал газрын тосны газрын даргын 2025 оны төлөвлөгөөний биелэлт, “Дотоод аудитын төлөвлөгөө”-ний дагуу шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд ХШҮДАГ-ын статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Б.Тэмүүжин дотоод аудит хийлээ.

“Шилэн дансны тухай”, “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг АМГТГ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн А/26 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байна.

Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны цахим санд мэдээлбэл зохих төсөв гүйцэтгэлийн 16 төрлийн мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 6 төрлийн мэдээлэл, бусад 7 төрлийн мэдээллийг бүрэн мэдээлсэн ба хуулийн хугацааг хоцроосон 4 мэдээлэл байршуулсан.

2022 онд хийсэн дотоод аудитаар хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл 6, 2023 оны байдлаар 6, 2024 оны жилийн эцсийн байдлаар 4 болж дотоод аудитаар өгсөн зөвлөмж үр дүнтэй болсон үзүүлэлттэй байна.

Зөрчлийн тоо бага хэдий ч хуулийн хугацаанд мэдээлэх үүргээ биелүүлж ажиллах шаардлагатай байна.

## **ГУРАВ. ТАНИЛЦУУЛГА**

Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийхдээ 2024 оны шилэн дансны цахим санд оруулсан мэдээлэл, агентлагийн даргын 2024 оны жилийн эцсийн байдлаар 134 ширхэг А тушаал, 177 ширхэг Б тушаалтай танилцаж, аудитыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2024 оны жилийн эцсийн байдлаар АМГТГ-ын данснуудын хуулгыг Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс гаргуулан авч шилэн дансны цахим санд оруулах мэдээллийг бүрэн гүйцэт цаг хугацаанд нь мэдээлсэн байдалд хяналт тавьж дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.

Агентлагийн даргын “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/18 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөнд тус мэдээллийг байршуулан ажиллаж байсан мэргэжилтнүүд бүтцээр өөрчлөгдсөн тул шинээр томилогдсон ажилтан албан хаагчдад ажлын хэсгийн нарийн бичиг болон байгууллагын админы хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд заавар зөвлөмж хүргүүлж ажилласан. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Комиссын бүрэлдэхүүн батлах тухай” тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүн байнгын давтамжтай үнэлгээний хороонд ажилладаг бөгөөд тус гишүүдийг сонгон шалгаруулалтын комисст ажиллахад тухай бүр “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг үнэлгээний хорооны нарийн бичгээс авч шилэн дансны мэдээллийн санд оруулж ажлын хэсэг нягт уялдаа холбоотой, ажиллах талаар ХШҮДАГ-аас зөвлөмж хүргүүлсэн.

## **ДӨРӨВ. АУДИТЫН ДҮН**

Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журамд тус тус заасныг бүрэн хэрэгжүүлж, Шилэн дансны нэгдсэн цахим санд 29 төрлийн мэдээллийг 439 удаа хандалт хийж хуулийн хугацаанд 179 мэдээллийг байршуулсан ба 4 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан талбарын мэдээллийг 1 болон 6 дугаар сард, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг 6 сард Санхүү, хөрөнгө оруулалтын

хэлтсийн ахлах нягтлан бодогч С.Түмэн-Ундармаа хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн.

Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг 10 дугаар сард Төрийн захиргаа удирдлагын газрын мэргэжилтэн Т.Болорцэцэг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, мэдээллийн тухай бүр шилэн дансны санд байршуулах мэдээллийг Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Т.Болорцэцэг Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүрд нь мэдээлж ажиллажээ.

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр байршуулах мэдээллийг ТЗУГ-ын Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан Д.Баасан 3 дугаар сард Б/40, А/42 дугаар тушаал, 04 дугаар сард А/53 дугаар тушаал, 05 дугаар сард А/67 дугаар тушаал, ТЗУГ-ын Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан Г.Буян-Аривжих 06 дугаар сард А/70, А/71, А/72, А/73 дугаар тушаал, 07 дугаар сард А/83, Б/104 дүгээр тушаал, 09 дүгээр сард А/94, А/95 дугаар тушаал, 11 дүгээр сард А/115, А/122, Б/156 дугаар тушаал, 12 дугаар сард Б/160, Б/172 дугаар тушаал тушаалыг журмын 10 дугаар хавсралтад заасан маягт болон PDF форматаар шилэн дансны цэсэд байршуулаагүй байсанд зөвлөмж хүргүүлсэн.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 797,445,760 төгрөгийн мэдээллийг дутуу мэдээлсэн байсанд мэдээллийг нөхөн оруулж, цаашид анхаарч ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Мөн дээрх мэдээлбэл зохих чиг үүрэгт хамааралгүй байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой 1 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим санд байршуулсан байдалд зөвлөмж өгсөн.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, (Тухай бүр) нийт мэдээлбэл зохих 1,624 нэр төрлийн, орлогын 335,959,867,037 төгрөг, зарлагын 297,931,018,093 төгрөгийн мэдээллийг

шилэн дансны цахим хуудсанд хуулийн хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж ажилласан байна.

## **ТАВ. ДҮГНЭЛТ**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “*тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх*” гэсэн заалтад нийцүүлж, агентлагийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг чиг үүргээ [“Сайн”](#) үнэлгээтэй хэрэгжүүлсэн.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “*Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна*” гэсэн заалтын дагуу цахим самбар байршуулж, нээлттэй ил тод мэдээллээр олон нийтийг чөлөөтэй танилцах боломжийг хангаж ажилласан байна.

## **ЗУРГАА. ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

1. Шилэн дансны мэдээлэл байршуулах эрх бүхий ажилтны үүрэг хариуцлагыг дээшлүүлж мэдээллийг үнэн зөв, бодитой, хуулийн хугацаанд бүрэн гүйцэд шилэн дансны цахим хуудсанд байршуулж хэвших;
2. Заавар зөвлөмж авсан албан хаагчид зөвлөмжийг хэрэгжүүлж, анхаарч ажиллах.
3. АМГТГ-ын даргын 2024 оны 02 дүгээр сарын 26-ний өдрийн “Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” А/26 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тухайн мэдээллийг хариуцан ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид мэдээлэл солилцож, ажлын нягт уялдаа холбоотой ажиллаж, заавар, зөвлөмж авах;
4. Мэдээллийг нэмж оруулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж өөрчлөгдөх тул Сангийн яамны шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнаас асууж зөвлөгөө авах;
5. Шинэчилсэн системээр тухай бүр оруулах мэдээллийг хуулийн дагуу 7 хоногийн дотор оруулахыг анхаарч ажиллах. /Орлого, зарлагын гүйлгээ, тушаал шийдвэрүүд гэх мэт 7 хоногийн дотор оруулах мэдээллүүд хамаарна/
6. Зарим маягтыг бөглөхгүй гэж сонгосноос шалтгаалан байгууллагын оруулах мэдээлэл дутах алдаа дутагдал илэрсэн. Оруулах мэдээлэл

байхгүй гэж сонгон хадгалсан бол ил тод болгож байх. /Ингэж сонгосон тохиолдолд уг маягт хугацаандаа орсон төлөвөөр харагдах болно./

7. Программаас шууд татагдаж ордог мэдээллийг үнэн зөв гүйцэт орж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах, шаардлагатай тохиолдолд Сангийн яамны шилэн данс хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэхийг тус тус зөвлөмж болгож байна.

Танилцсан:

АМГТГ-ын дарга

Ш.Ганхуяг

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Д.Оюунцэцэг

Тайлан бичсэн:

ХШҮДАГ-ын мэргэжилтэн

Б.Тэмүүжин

Танилцсан:

ТЗУГ-ын мэргэжилтэн

Т.Болорцэцэг

ТЗУГ-ын архив, бичиг хэргийн  
ажилтан

Б.Дашмаа

СХОХ-ийн ахлах нягтлан  
бодогч

С.Түмэн-Ундармаа

СХОХ-ийн  
эдийн засагч

Б.Ариунаа

Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар:

.....

.....

.....

.....

.....

.....

.....